

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ



Махатма Ганди мэндэлсэн 154 дах жилийн ойг тохиолдуулан Бүгд Найрамдах Энэтхэг Улсын Элчин Сайдын Яамнаас зохион байгуулсан МАХАТМА ГАНДИЙН ХӨШӨӨНД ЦЭЦЭГ ӨРГӨЖ, ХҮНДЭТГЭЛ ҮЗҮҮЛЭХ” ёслолын уламжлалт арга хэмжээнд Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл Урлалын Политехник коллежийн захирал Д.Буяндэлгэр цэцэг өргөж, мэндчилгээ дэвшүүлэн, багш суралцагчдын төлөөллийн хамт оролцож хүндэтгэл үзүүллээ

Үйлдвэрлэл Урлалын Политехник Коллежийн хамт олон Барилга Политехник Коллежийн хамт олонд хүндэтгэл үзүүллээ



НҮБ 1994 оноос эхлэн жил бүрийн 10 дугаар сарын 5-ны өдрийг Дэлхийн багш нарын өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлж байгаатай холбогдуулан Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн Оюутны зөвлөл Сургалтын албатай хамтран 2024-2025 оны хичээлийн жилийн Багш нарын баярыг угтан оюутны нэг өдрийг “Багшаа дээдэлье” уриатай зохион байгууллаа



WORLD K-BEAUTY FESTIVAL-2024 Nail art, Eyelashes) тэмцээн 12 дах удаагаа зохион байгуулагдлаа

Энэхүү тэмцээнд Гоо сайхны үйлчилгээ Заангийн Ө.Намуунзул классак сормуус суулгах төрлөөр Тэргүүн байр алтан цом А.Учрал салон маникюр төрлөөр Тэргүүн байр алтан цом, гелин хумс уртасгах төрөлд Гранпри цом авч амжилттай оролцлоо



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ПИЙРСОН (PEARSON ВТЕС) ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТЭД МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Дархан-Уул аймаг дахь Дархан политехник коллежийн хөтөлбөрийн багт Pearson ВТЕС мэдээллийн технологийн хөтөлбөрийн агуулга, үнэлгээний явцын зураглал тодорхойлох, үнэлгээний аргачлал, төлөвлөгөө боловсруулах, сайн туршлага, арга зүйг хуваалцаж түгээн дэлгэрүүлэх, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх сургалтыг IEDC Пийрсон хөтөлбөрийн Монгол дах төлөөлөгч Үйлдвэрлэл Урлалын политехник коллеж, Техник техникийн политехник коллежтой хамтран зохион байгууллаа



Нийгмийн хариуцлагын хүрээнд ҮУПК-н Нийгмийн ажилтан В. Гэрэлцэцэг Урлал дизайны тэнхимийн Ц.Давааням багштай У32а Н.Саруул багштай У33а ангийн 10 суралцагч Сүхбаатар дүүргийн Хүүхэд хамгааллын төвд цогц зураг зурж хүлээлгэн өглөө



ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ ТЭНХИМИЙН БАГШ НАР МОД ТАРИВ

ҮУПК “ийн Хүмүүнлэгийн ухааны тэнхимийн багш нар “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд ажлын төлөвлөгөөнд заасан хуваарийнхаа дагуу Эко цэцэрлэгт хүрээлэн” – д мод тарьж байгаль эх дэлхийгээ хайрлах аянд нэгдлээ



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

УУПК- ИЙН ТЭНХИМҮҮД САР БҮР ХАРИУЦАН ЗОХИОН БАЙГУУЛДАГ "ЁС ЗҮЙ, ХАНДЛАГЫН САРЫН АЯН"-Г ХОЁР ДАХЬ ЖИЛДЭЭ АМЖИЛТТАЙ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА

- 2024-2025 оны хичээлийн жилийн аяныг сургуулийн ёс зүйн дэд хороо, ХУТ -ийн хамт олон албан ёсоор эхлүүлээ
- Нээлтийн үйл ажиллагаанд сургуулийн захирал Д.Буяндэлгэр, сургалтын албаны менежер Б.Мядагбадам нар хамт олондоо амжилт хүсч нээлтийн үг хэллээ
- Сургуулийн дотоод чанарын баталгаажуулалтын ахлах ажилтан С.Лувсанвандан шинэчлэн байгуулагдсан сургуулийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүн болон төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, багшийн ёс зүйн дүрмийн талаар мэдээлэл хийв



Мөн ХУТ-ийн хамт олноос тус аяны хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг танилцуулж багш ажилчдад ёс зүйн гарын авлагыг гардууллаа



ҮЙЛДВЭРЛЭЛ УРЛАЛЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ХАМТ ОЛОН АХМАД БАГШ АЖИЛТНАА ХҮЛЭЭН АВЛАА

Ахмадын баярын 32 дах өдрийг тохиолдуулан Ражив Гандийн нэрэмжит Үйлдвэрлэл урлалын политехник коллежийн хамт олон ахмад багш ажилтнаа хүлээн авч, хүндэтгэл үзүүллээ. Ирээдүй хойч үеийнхээ сайн сайхан, улс орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө залуу нас, халуун сэтгэлээ зориулан уйгагүй хөдөлмөрлөж, шаргуу зүтгэсэн үе үеийн багш ажилтандаа захирал Д.Буяндэлгэр талархал илэрхийлэн үг хэлж, багш, ажилтаны төлөөлөл мэндчилгээ дэвшүүлэн нэгэн өдрийг дурсамж дүүрэн өнгөрүүлээ.



СУРГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Зочид буудлын үйлчилгээний ангийн оюутнууд Хустайн байгалийн цогцолборт газар болон Хустай жуулчны баазтай танилцах аялал хичээл хийлээ



Мэргэжлийн ангийн оюутнуудыг үйлдвэрлэлийн орчинтой танилцуулан, байгаль хамгаалах сэтгэлгээтэй болох, суралцагчдын мэргэжлийн хүсэл сонирхол идэвхийг өрнүүлэх зорилгоор "Хустай-Тахийн өлгий нутаг" сэдэвт аялал хичээлийг мэргэжлийн ангийн оюутнуудыг хамруулан зохион байгууллаа



УУПК-ийн "Нарны охид" клубийн өдөрлөгт сургалтын менежер Б.Мядагбадам үг хэлж, МЗХ-ны дэргэдэх эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга Ж.Нямаа "Өөрийгөө таних 8 зарчим" сэдвээр сургалт орж УС-2а ангийн сурагч Э.Лувсан, А.Отгонбаяр нар ая дуугаа өргөн ОБУ-2а ангийн сурагч Б.Энх-Оюун бүжиглэж, охидод тулгамдаж байгаа асуудлын талаар ярилцлаа "Нарны охид" төслийг санаачлагч Ж.Нямаа дарга ном бэлэглэж, сэтгэлийн зурвас хайрцгийг аялуулахаар боллоо



НИЙГМИЙН ТҮНШЛЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

УУПК-ИЙН СУРГАЛТЫН АЛБА НИЙГМИЙН ТҮНШЛЭЛ БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТЭНХИМ ХАМТРАН АЖИЛ ОЛГОГЧДЫН УУЛЗАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

- Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага болон ажил олгогчид хамтран өгөгдлийн ухаан хөтөлбөрийг шинэчлэн сайжруулан хамтран боловсруулах, санал авах мэдээллийн технологийн мэргэжлийн ажил олгогчдын зөвлөл байгуулах, тус мэргэжлээр суралцаж буй суралцагчдыг дадлагажуулах, ажлаар хангах оновчтой арга замыг эрэлхийлэх, ажлын байранд зуучлах чиглүүлэх, ажил олгогчдын эрэлт хэрэгцээг судлах, түүнд тулгуурласан элсэлтийг зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх хамтран ажиллах, туршлага солилцон нэвтрүүлэхэд оролцогч талуудын хүчин чармайлтыг нэгтгэх зорилгоор Мэдээллийн технологийн салбарын ажил олгогчдын уулзалтыг зохион байгууллаа



Тус уулзалтанд төрийн болон хувийн өмчийн нийт 23 байгууллагын төлөөлөл оролцон цаашид хэрхэн хамтран ажиллах талаар харилцан ярилцаж санал дэвшүүлж цаашид хамтран ажиллахаар боллоо



ОХУ-ЫН ЭРХҮҮ ХОТЫН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ, СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД АЙЛЧЛАЖ, ТУРШЛАГА СОЛИЛЦЛОО

Гадаад хамтын ажиллагааны хүрээнд гаруй багш нарын төлөөлөл 2024.10.21-25-ны өдрүүдэд ОХУ-ын Эрхүү хотын “Эдийн засаг, аялал жуулчлал, ахуй үйлчилгээний коллеж”, “Хүнс, хоолны үйлдвэрлэлийн техникум”, “Нисэх үйлдвэрлэл материал боловсруулалтын техникум”, Ангарын үйлдвэрлэлийн техникум”-ын үйл ажиллагаатай танилцаж нээлттэй болон үзүүлэх хичээлд оролцож, түншлэгч ААНБ-аар зочлон сайн туршлага, арга зүйг хуваалцаж түгээн дэлгэрүүлэх туршлага судлалаа

Эрхүү хотын Боловсролын яамны мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга болон сургуулиудын удирдлага хүлээн авч уулзан хамтын ажиллагааны протоколд гарын үсэг зурлаа

